



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/118

Сангиндалай

Газар усны нэр тодруулах ажлыг хүлээн  
авах ажлын хэсэг байгуулах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа.ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дугаар зүйлийн 2.10 дахь заалт Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт, Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулах журмын 9.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрийн газар усны нэрийг тодруулах ажлын хүрээнд хийгдсэн ажлыг хүлээн авч, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Э.Ууганцэцэг (Газрын даамал)

Гишүүдэд:

Т.Энхбат (Сан хариуцсан нягтлан бодогч)

Ж.Түвшинбаатар (7-р багийн Засаг дарга)

М.Золжаргал (Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан  
ажилтан)

С.Бадамгарав (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Дээрх ажлын гүйцэтгэлд хяналт тавин хүлээж авахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Т. ЭНХДЭЛГЭР



482303035